ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
«НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ»
ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 4 сарын 29 өдөр    Дугаар 4/22    Улаанбаатар хот

"НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

ТУЗ-с гаргасан үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлан хэлэлцэх тухай

"Нэхээсгүй Эдлэл" ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-с гаргасан үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг авч хэлэлцээд Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.9, 63 дугаар зүйлийн 63.5, мөн хуулийн 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсгийг удирдлага болгон **ТОГТООХ нь**:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан 2021 оны тайлант хугацаанд эрхлэн явуулсан үйл ажиллагааны тайланг батлсугай.
2. Нийт хувьцаа эзэмшигчдэд танилцуулсан хараат бус Аудитын байгууллагын хийсэн санхүүгийн тайлангийн "Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын хүлээх хариуцлага"-д заасныг анхааралдаа авч удирдлага болгон ажиллахыг ТУЗ-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА    Б.ГАНБАТ

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
«НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ»
ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 4 сарын 29 өдөр Дугаар 5/22 Улаанбаатар хот

"НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн 2021 оны үйл
ажиллагааны тайлан батлах тухай

"Нэхээсгүй Эдлэл" ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-с гаргасан компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг авч хэлэлцээд Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.14, мөн хуулийн 63.5 дахь хэсгийг, 69 дугаар зүйлийн 96.4-т заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан ТУЗ-өөс гаргасан компанийн 2021 оны үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтын талаарх тайланг авч баталсугай.
2. Цаашид компанийн үйл ажиллагааг тогтвортой, энэхүү бүтэц, зохион байгуулалтаар ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Б.ГАНБАТ

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ

«НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ»

ХУВЬЦААТ КОМПАНИЙ

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 4 сарын 29 өдөр Дугаар 6/22 Улаанбаатар хот

НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн 2022 оны бизнесийн төлөвлөгөөг хэлэлцэх тухай

"Нэхээсгүй Эдлэл" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-с гарсан 2022 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцээд Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, 62 дугаар зүйл 62.1.15 дахь хэсгийг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг улирал, хагас жил, жилээр хэлэлцэж батлах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан ТУЗ-өөс гаргасан компанийн 2021 оны үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтын талаарх тайланг авч баталсугай.
3. 2022 оны ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Б.ГАНБАТ

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
«НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ»
ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 4 сарын 29 өдөр Дугаар 7/29 Улаанбаатар хот

НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

ТУЗ-ийн гишүүдийг
томилох тухай

"Нэхээсгүй Эдлэл" ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн ТУЗ-н гишүүдийг сонгох тухай санал хураагаад компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.7 дахь хэсэг, мөн хуулийн 63 дугаар зүйлийн 63.5-д заасныг удирдлага болгон хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

Ердийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр:

1. Б.ГАНБАТ
2. Б.МӨНХДАЛАЙ
3. Б.МӨНХТӨР
4. БАТ-ЭРДЭНЭ
5. Г.МӨНХЦОЛМОН
6. Г.МӨНХЦЭЦЭГ

Хараат бус гишүүдээр:

7. Л.ТҮВШИНБАТ
8. Б.НЯМЦЭРЭН
9. П.ЗОЛЖАРГАЛ нарыг Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан хугацаагаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр томилсугай.

НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ ХК УЛААНБААТАР ХОТ

ХУРЛЫН ДАРГА Б.ГАНБАТ